

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛ**

ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХУРАЛДААНЫ ТОЙМ

2020 оны 07 дугаар сарын 01

Улаанбаатар хот

д/д	Хэлэлцсэн асуудал	Хуралд- сан огноо	Хэлэлцүүлсэн гишүүн	Хуралдаанаас гарсан шийдвэр, түүний хэрэгжилт
1	2	3	4	5
1	Салбар зөвлөлийн хуралдааны дэгийг төслийн хэмжээнд хэлэлцэх	02-р сарын 21-ний өдрийн 14:30 цагт	Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Ж.Алтангэрэл	Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийг 9 гишүүнтэй байгуулсан. Тус салбар зөвлөл анхны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэн шийдвэрлэж тогтоол гарсан. - Салбар зөвлөлийн хуралдааны дэгийг 01 дүгээр тогтоолоор баталсан. - 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 19 арга хэмжээ тусган хэрэгжүүлэхээр 02 дугаар тогтоолоор баталсан. - Удирдах 2 албан тушаал, 9 гүйцэтгэх албан тушаалын сул орон тооны захиалгыг 03 дугаар сарын 03-ны өдрийн 03, 04 дугаартай албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзоригт хүргүүлсэн.
2	Салбар зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах		Салбар зөвлөлийн гишүүн, дэд дарга Д.Түвшинтөр	
3	Сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх асуудлыг хэлэлцэх			
4	Салбар зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарь хэлэлцэж батлах	03-р сарын 27-ны өдрийн 11:00 цагт	Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Ж.Алтангэрэл	Салбар зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг гишүүн тус бүрээр хэлэлцэн 03 дугаар тогтоолоор баталсан бөгөөд гишүүд хуваарийн дагуу хийсэн ажлыг мэдээ тайлан ирүүлж байна.
5	Төрийн захиргааны албан хаагчид зэрэг дэв шинээр болон ахиулан олгох санал гаргах		Салбар зөвлөлийн гишүүн, Захиргаа, удирдлагын газрын дарга Д.Давааням	Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг олгох албан хаагчдыг нэг бүрчлэн хэлэлцүүлснээр 8 албан хаагчид олгох саналыг гаргаж, салбар зөвлөлийн 04 дүгээр сарын 28-ны өдрийн 07 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид хүргүүлсэн. Үүний үр дүнд сайдын 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/82 дугаар тушаалаар төрийн захиргааны 2 албан хаагчид зэрэг дэвийг шинээр, 6 албан хаагчид зэрэг дэвийг ахиулан олгосон.
6	Гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалт зохион байгуулах шалгалтын комиссыг байгуулж, чиглэл өгөх тухай	04-р сарын 15-ны өдрийн 10:30 цагт	Салбар зөвлөлийн гишүүн, Захиргаа, удирдлагын дарга Д.Давааням	Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 04 дүгээр сарын 16-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалт зохион байгуулах шалгалтын комиссыг 5 албан тушаалтны бүрэлдэхүүнтэй байгуулсан. Комиссын даргаар Захиргаа, удирдлагын газрын дарга Д.Давааням, гишүүдээр Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтсийн дарга Л.Батсүх, Хяналт

1	2	3	4	5
				шалгалтын газрын хяналтын улсын ахлах байцаагч Н.Дуламсүрэн, Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн хуулийн ахлах мэргэжилтэн М.Уранбилэг, нарийн бичгийн дарга Захиргаа, удирдлагын газрын хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Алтангэрэл нар томилогдсон. Мөн тусгай шалгалт зохион байгуулах ажлын төлөвлөгөөг салбар зөвлөлийн дарга Д.Мөрөн батлан комиссын дарга, нарийн бичгийн дарга нарт Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 141 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах талаар чиглэл өгсөн.
7	Гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалт зохион байгуулсан шалгалтын комиссыг тайлан	04-р сарын 23-ны өдрийн 14:00 цагт	Салбар зөвлөлийн гишүүн, Захиргаа, удирдлагын дарга Д.Давааням	Улсын онцгой комиссын 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэлээр өгсөн чиглэлийн дагуу Төрийн албаны зөвлөлөөс “Төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр сарын 13-ны өдрийн 141 дүгээр тогтоол гарч, хялбаршуулсан горимоор тусгай шалгалт зохион байгуулах аргачлалын дагуу ажилласан. Тус комисс зарлагдсан 9 албан тушаалд өрсөлдөхөөр ирүүлсэн 20 иргэний материалыг хянаж шаардлага хангасан 4 иргэнийг бүртгэж, шалгалтыг 04 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Комиссын тайланг Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 04 дүгээр сарын сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, тэнцсэн 3 иргэнийг нэр дэвшүүлсэн тогтоол гаргасан. Мөн нөхөж чадаагүй 6 албан тушаалд Төрийн албаны тухай хуулийн 27.1.3, “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 2.3.2-т заасны дагуу төрийн жинхэнэ албаны нөөцөд байгаа иргэдээс сул орон тоог нөхөх хоёр дахь шатны шалгаруулалт явуулах захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.
8	Салбар зөвлөлийн эхний хагас жилийн тайлан, төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар	06-р сарын 30-ны өдрийн 11:00 цагт	Нарийн бичгийн дарга Ж.Алтангэрэл	Эхний хагас жилийн тайлан болон төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцлээ. “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын дагуу тайланг хэрэгжүүлэх чиг үүрэг тус бүрээр нэгтгэн, хавсралтын хамт 06 дугаар сарын 30-ны өдрийн 10 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзоригт хүргүүлсэн. Үүнд: - 1 дүгээр хавсралтаар тайлан, - 2 дугаар хавсралтаар төрийн жинхэнэ албан тушаал эрхэлж байгаа албан хаагчийн нөөцийн бүртгэл, - 3 дугаар хавсралтаар төрийн жинхэнэ албанаас чөлөөлөгдсөн албан хаагчийн болон иргэний нөөцийн бүртгэл,

1	2	3	4	5
				<p>-4 дүгээр хавсралтаар сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчдын судалгаа, -5 дугаар хавсралтаар байгууллагын үйл ажиллагааны тайлан бүхий сэтгүүлийг тус тус хүргүүлсэн.</p>

САЛБАР ЗӨВЛӨЛ